



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022.02.14

№ АЗТУЗ2022003

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02 сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 60.1 дэх заалт, 76 дугаар зүйл, 76.1.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Монгол Улсын хэмжээнд цар тахал хурдацтай тархаж байгаа улмаас Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 01 сарын 05-ны өдөр хүргүүлсэн 9/53 тоот албан тоот даалгаврын дагуу Алтайн Зам ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 03 сарын 28-ны Даваа гарагийн 16:00 цагт Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд ZOOM программ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулахаар товловсугай.

ХОЁР. Хурлаар хэлэлцэх асуудал болон хуралдааны дэгийг Тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.

ГУРАВ. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Нямдавааг томилсугай.

ДӨРӨВ. Хурал зохион байгуулах болон тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

- | | |
|-------------------|---------------------------------------|
| ➤ Комиссын дарга | Э.Өлзийхутаг / Ерөнхий нягтлан бодогч |
| ➤ Комиссын гишүүн | Д.Дэлгэрсүрэн /Хүний нөөцийн менежер |
| ➤ Комиссын гишүүн | Б.Бат-Эрдэнэ/ Ерөнхий менежер |

ТАВ. Хуралд оролцох эрхтэй, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 03 дугаар сарын 8-ны өдрөөр тасалбар болгож, олон нийтэд 2022 оны 03 сарын 13-ний өдөр мэдээлсүгэй.

ЗУРГАА. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өгөх, хавсралт №2-д заагдсан баримт бичигтэй танилцуулах ажлыг 2022 оны 3 сарын 9-ний өдрөөс 2022 оны 3 сарын 12-ний өдрүүдэд хувьцаа эзэмшигч нарт хүндрэлгүйгээр, цахим хэлбэрээр танилццах боломжоор ханган ажиллахыг зохион байгуулах комисст даалгасугай.

ДОЛОО. Санал авах хуудасны загварыг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 880 тоот тогтоолоор батласан журмын дагуу тогтоолын хавсралт №3-д зааснаар баталж, Хувьцаа эзэмшигчдийг эчнээ санал өгөх боломжоор хангах ажлыг зохион байгуулахыг ТУЗНБД Б.Буянзаяад үүрэг болгосугай.

НАЙМ. Эчнээ саналын хуудас хүлээн авах өдрийг 2022 оны 03 сарын 14-ний өдөр эхлүүлж 2022 оны 3 сарын 24-ний өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

ЕС. Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батласан журмын дагуу түгээхийг ТУЗНБД Б.Буянзаяад даалгасугай.

АРАВ. Хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчид болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, харилцагч брокерын үйлчилгээ үзүүдэгч компаниуд руу хүргүүлэн ажиллахыг Комисст даалгасугай.

АЗТУЗ2022003 тоот тогтоолын хавсралт №1
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТОВ



№	Хэлэлцэх асуудал	Хариуцан танилцуулах, гүйцэтгэх хүн	Шийдвэрийг төсөл	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх Ирцийг танилцуулах	ТУЗНБД Б.Буянзаяа		16:00-16:30 ZOOM программыг нээж хувьцаа эзэмшигч нарт ID болон PASS кодыг илгээх
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон дэгийг танилцуулах	Хурлын дарга М.Нямдаваа		16:30-16:35
3	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуун	АЗХЭ2022001	16:35-17:35
4	Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай тогтоол	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх		
5	ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ТУЗ-ийн дарга М.Нямдаваа	АЗХЭ2022002	
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	Нэр дэвшүүлэх хорооны дарга С.Балжинням	АЗХЭ2022003	
7	УБГ дээрх хувьцааны тоог залруулах тухай	ТУЗНБД Б.Буянзаяа	АЗХЭ2022004	
7	Санал хураалт			17:35-17:50
8	Тооллогын комиссын тогтоол танилцуулах			17:50-18:00
9	Хурлыг хаах			18:00-18:10

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. 2021 оны санхүүгийн тайлан
2. 2021 оны үйл ажиллагааны тайлан
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт
4. 2021 оны ТУЗ-ийн тогтоолууд
5. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
7. ТУЗ-ийн зардлын төсөв
8. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга
9. 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоол



АЗТУЗ2022003 тоот тогтоолын хавсралт №3

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС

1. Хувьцаа эзэмшигчийн овог _____
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр _____
3. Хувьцаа эзэмшигчийн нэр _____
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл _____
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар _____
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
7. Санал өгөх хувьцааны тоо _____
8. Бүртгэсэн / брокер, диллер/ компанийн нэр _____
9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	АЗХЭ2022001 2021 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай			
2	АЗХЭ2022002 2021 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай			
3	АЗХЭ2022003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай			
4	АЗХЭ2022004 УБГ-н дээрх хувьцааны тоог залруулах			

Кумулятив аргаар санал өгөх (ТУЗ-ийн гишүүн сонгох)

ТУЗ-ийн гишүүдийн тоо	Нийт саналын эрхийн тоо	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид өгсөн саналын хуваарилалт					Хараат бус гишүүдэд нэр дэвшигчдэд өгсөн саналын хуваарилалт		
9									

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ _____ / _____ /
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____

Өдөр тутмын хэвлэлд өгөх зарын төсөл



АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Алтайн Зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 03 дугаар сарын 28-ны Даваа гарагийн 16:00 цагт Алтайн зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд ZOOM программаар дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, Хүнсчдийн гудамж, Алтан тариа ХК-ийн байрны баруун талд, Алтайн Зам ХК-ийн байр

Хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нар нь 2022 оны 03 сарын 11-ны өдрийн дотор Хурал зохион байгуулах комиссын даргатай 99155646 дугаараар болон secretaryaz@altainzam.mn цахим хаягаар холбогдож, хуралдаанд оролцох, санал өгөх заавар зааварчилгааг урьдчилан авна уу.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2019.03.08

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол хуваарилахгүй байх тухай тогтоолын танилцуулга
- ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай
- УБГ дээрх хувьцааны тоог залруулах тухай

Хурлын материал болон, шийдвэрийн төсөл холбогдох бусад баримттай ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд 99155646 дугаарын утсанд болон secretaryaz@altainzam.mn цахим хаягаар холбогдож цахим шуудангаар дамжуулан авах бүрэн боломжтой.

Холбоо барих:

ТУЗНБД 99992301

Цахим шуудангийн хаяг: secretaryaz@altainzam.mn

Цахим хуудас: www.altainzam.mn

АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН 2022 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Алтайн Зам ХК
Хаяг, утас	Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан баг өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг	2022-03-28-ны 16:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	СХД, 4-р хороо Хүнсчдийн гудамж, Алтан Тариа ХК-ийн баруун талд Алтайн Зам ХК-ийн байр

ЭЭЛЖИТ

Хурлын төрөл:	ээлжит бус
---------------	------------

ТУЗ

Хурал зарлагч	ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
---------------	--

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2022-02-14
---------------------------------------	------------

Олон нийтэд зарлах огноо	2022-02-17
--------------------------	------------

Бүртгэх өдөр	2022-03-08
--------------	------------

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2022-02-15
---	------------

Хүргүүлсэн огноо

Хурлын даргын нэр	М.Нямдаваа
-------------------	------------

Тооллогын комиссийн дарга, гишүүдийн нэр	Э.Өлзийхутаг /Ерөнхий нягтлан бодогч/ Б.Бат-Эрдэнэ/ Ерөнхий менежер/ Д.Дэлгэрсүрэн /Хүний нөөцийн менежер/
--	--

Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/

Баримт, бичгийн хуудсын тоо ширхэг хуудас
-----------------------------	------------------------------

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОММИССЫН ДАРГА

.....
Э.Өлзийхутаг/

